

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 8 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Тэжон хотын Со дүүргийн Засаг даргын орлогчоор ахлуулсан төлөөлөгчид 8 дугаар сарын 5-8-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт ажиллаж байна. Энэ удаагийн айлчлалын төлөөлөгчид Солонгос улсын эрүүл мэндийн аялал жуулчлалын танилцуулга мэдээллийг Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв, Төрийн албан хаагчдад хийлээ. Мөн аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар, Аймгийн Засаг дарга Л.Ганболд нартай албан уулзалт хийж харилцан санал солилцов.

Шинэ хичээлийн жилийг угтсан Хөвсгөл аймгийн боловсролын салбарын багш нарын бага хурал болж 2018-2019 оны хичээлийн жилийн зорилго, зорилтын хэрэгжилт, 2019-2020 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх зорилго, зорилтыг хэлэлцүүлж танилцууллаа. Мөн БСШУСЯ, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэнгээс хамтран зохион байгуулсан “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сургалтад аймгийн боловсролын байгууллагын нийт удирдах ажилтан, багш, нийгмийн ажилтан, мэргэжилтнүүд оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор жил бүр зохион байгуулагддаг улсын аварга шалгаруулах хөл бөмбөгийн “Үндэсний цом- 2019” тэмцээн Мөрөн суманд зохион байгуулагдаж 18 аймгийн баг тамирчид хурд, хүчээ сорин дээд шатанд Орхон, Дархан, Увс аймаг, нэгдүгээр шатанд Сүхбаатар, Хөвсгөл, Сэлэнгэ аймгийн баг тамирчид тэргүүлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Цаатны наадам-2000 цааны баяр”-ын арга хэмжээ Цагааннуур суманд амжилттай зохион байгуулагдлаа. Цаатан иргэд цаан сүргээ өсгөн үржүүлж 1990 онд анх 1000 цааны баяр хийж байсан бол энэ жил Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор 2000 цааны баярын арга хэмжээг өргөн дэлгэр тэмдэглэж гадаад дотоодын 5000 гаруй жуулчид, зочид төлөөлөгчид тус баярын арга хэмжээг үзэж сонирхлоо.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2019 оны 8-р сард 46 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 10.8 тэрбум төгрөгний 1,682 ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 7-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 5.970,3 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 6.727,6 сая төгрөг буюу 112.7% хувийн гүйцэтгэлтэйгээр давуулан биелүүсэн байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 62.611,8 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 33.393,5 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 28.731,6 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 452.0 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 4.528,9 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 69.665,8 сая төгрөг, Зарлагын гүйцэтгэл 67.768,3 мянган төгрөг буюу 97.3% хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага 5.058,8 сая төгрөг өмнөх сараас 1.371,3 сая төгрөгөөр өссөн байна. Нийт өглөг 1.630,5 сая төгрөг өмнөх сараас 59.1 сая төгрөг өссөн байна.

2019 оны 08 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 1156,0 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 118,3 сая төгрөгийн , шимтгэлийн орлого 110,2 % -аар биелсэн байна

Тэтгэврийн даатгалын сангаас 18387 тэтгэвэр авагчид 5899,7 сая төгрөгийн 3 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 185 даатгуулагчдад 216,9 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 78 даатгуулагчдад 39,3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 532,3 сая төгрөг байна.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс аймгийн Цагдаагийн газарт “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр ашиглах 100 ширхэг 200 метр хамгаалалтын хайсыг хүлээлгэн өглөө. Тус хамгаалалтын хайс нь нийт 9,950,000 төгрөгийн үнэтэй. Мөн тус Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт “Хэргийн газарт ажиллаж буй албан хаагчдыг онлайнаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангах тоног төхөөрөмжийн хөдөлгөөн тогтворжуулагч гар”-ыг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 500,000 төгрөгөөр худалдан авч хүлээлгэн өглөө.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт “Цагдан хоригдож буй хоригдлуудыг эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх боломж нөхцлийг хангах зорилгоор мэдүүлэг авах өрөөг телекамер, дуу хураагуураар хангалаа. Тус тоног төхөөрөмжийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас 840,000 төгрөгөөр санхүүжүүллээ.

Орон нутгийн зам- Хөдөлгөөний соёл” үндэсний хэмжээний аяны хүрээнд Хөвсгөл аймаг дахь Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасагт 200 литр шатахууныг өгч Тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалт явуулан ажиллаж байна. Тус аяны хүрээнд 8 дугаар сард Мөрөн-Тариалан, Мөрөн-Алаг-Эрдэнэ чиглэлд хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтаар ажиллаж тус хяналт шалгалтаар хурд хэмжигч багажаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хурд хэмжигч багажаар хурд хэмжиж 1923 тээврийн хэрэгсэл шалгаж 605 зөрчил илрүүлж 605 хүнийг 20,940,000 төгрөгөөр, хурд хэтрүүлсэн 385 жолоочид 19,250,000 төгрөгөөр торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна.

Ханх боомтоор нэвтэрч буй тээврийн хэрэгсэл бүрд ариутгалын баннаар дамжуулан туулуулах байдлаар ариутгал халдваргүйтгэлийг хийж байна. 2019 онд нийт ОХУ-аас хорио цээрийн хяналт, баталгаажуулалтын эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээ, амьтны эрүүл мэндийн дэвтрийг үндэслэн нийт 157 импортын гэрчилгээ бичиж 1570000 төгрөгийг төвлөрүүлсэн, импортын мэдэгдэл 17 бичигдсэн байна. Ханх боомтоор хууль бусаар, дагалдах баримт бичиггүй мал, амьтан тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн хүнсний ногоо, мах, байгалийн ховор ургамал нэвтрээгүй, хяналт шалгалтыг чангатгаж ажиллалаа.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн нэгжүүдэд тандалт судалгаанд нийт 75 ААНБ хамрагдахаас 09 сарын 08-ны байдлаар 50 ААНБ хамрагдаж, гүйцэтгэл 66.0 хувьтай байна. Тандалт судалгаанд илэрсэн зөрчлийн дагуу ААНБ-ууд зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.

Бүх шатны боловсролын байгууллагын 2019-2020 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл хангагдсан эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийлээ. Шалгалтад нийт 243 зөрчил илрүүлсэн бөгөөд шалгалтын хугацаанд зөрчлийн 60 хувийг арилгуулж, үлдсэн зөрчлийг арилгуулахаар 49 заалт бүхий 7 албан шаардлага, бусад бүх сургууль цэцэрлэгт тус бүр 12 заалт бүхий нэгдсэн зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

2019 оны 08 сарын байдлаар гэмт хэрэг өмнө оны мөн үеэс 84 буюу 15,8 %-аар буурсан дүнтэй. Захиргааны зөрчил өмнө оны мөн үеэтэй харьцуулахад 2550 буюу 37,8 %-аар өссөн. Үүнээс: Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 26 буюу 60%-аар буурсан, хулгайн гэмт хэрэг 90 буюу 44,3 %-аар буурсан байна.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Аймгийн БСУГ, ГБХЗХГ, ДЗОУБ хамтран "Эерэг хүмүүжлийн арга" сургагч багш бэлтгэх сургалтыг 8-р сарын 18-19-нд амжилттай зохион байгууллаа. Сургалтад сургууль бүрээс 3-4 багш хамрагдаж 1-р шатны агуулгыг амжилттай дүүргэлээ.

"Сургалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх арга зүй" сургалтыг улсын хэмжээнд бэлтгэгдсэн 44 багш ирж 4 өдрийн турш нийт сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, мэргэжлийн багш, нийгмийн ажилтан зэрэг 2000 албан хаагчдад зохион явууллаа.

Аймгийн багш нарын бага хурлыг 8-р сарын 26-ны өдөр зохион байгуулж 360 багш сурган хүмүүжүүлэгчид оролцлоо. Бага хурлаас 2018-2019 оны хичээлийн жилийн зорилго зорилтоо дүгнэн хэлэлцэж, 2019-2020 оны хичээлийн жилийн зорилго зорилтоо тодорхойллоо.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор "Хурд" хамтлагийн санаачилсан "Хайртай" аян 2019 оны 08 дугаар сарын 29,30-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт зохион байгуулагдлаа.

Монголын Үндэсний музей, АНУ-ын Питсбургийн их сургууль, Америкийн Монгол Судлалын төвтэй хамтран Дархадын хотгорын сав нутагт археологийн судалгааны "Умард Монгол" төслийг хамтран хэрэгжүүлдэг. Төслийн багийн эрдэмтдийн энэ зуны малтлагын үр дүнд дэлхийн археологийн шинжлэх ухаанд нээлт болохуйц, Монголын эзэнт гүрний язгууртнуудад холбогдох цоо шинэ олдворуудыг нээжээ. Уг судалгааны баг 2018, 2019 онд Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Мунгараг багийн нутаг "Хориг" хэмээх газарт тонож сүйтгэгдсэн Монголын эзэнт гүрний үед холбогдох бүлэг булшийг авран хамгаалах, үлдэж хоцорсон эд өлгийн зүйлсийг цуглуулах ажлыг хийлээ. Эдгээр тоногдсон булшны шороо, ухсан нүхийг нягтлан шалгах явцад Эзэнт гүрний үед холбогдох судалгаа болон үзмэрийн маш өндөр ач холбогдолтой олон тооны олдворууд илэрлээ. Эдгээрийн дотор 700 - 800 жилийн тэртээ мөнх цэвдэгт тэс хөлдүү хадгалагдсан гурван ваар дүүрэн өрөм, нэг ваар дүүрэн шар тос нь Монголын төдийгүй дэлхийн археологийн судалгаанд нэн ховор нээлт болж буй олдворууд юм.

"Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар"-ын хүрээнд эмч мэргэжилтнүүдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Монголын Анагаах Ухааны Эрх зүйн холбооны дарга Э.Ганбатыг урьж эмнэлгийн ажилтан, албан хаагч нарт "Анагаах ухааны эрх зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 63 эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд хамрагдсан байна. Сургалтаар Анагаах ухааны эрх зүй, анагаах ухааны үндсэн асуудал, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, ёс зүй, эрх зүйн үндсэн чиглэлээр арга зүйн сургалт болон онол дадлага хосолсон үр дүнтэй зохион байгуулагдлаа.

Аймгийн ЭМГ, Мэргэжлийн хяналтын газартай хамтран Мөрөн сумын ЕБС, СӨББ-ийн захирал дарга, эмч, дотоод хяналтын ажилтнууд, Хүнс үйлдвэрлэгчдэд сургалт зохион байгуулж, хүүхдийн хоол тэжээл илчлэг тооцох, цаашид анхаарах асуудал, ариутгал халдваргүйтгэл, хоолны хордлого, багш ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэг, үнэ тариф, хичээлийн шинэ жилд эрүүл мэндийн чиглэлээр анхаарч ажиллах зарим асуудлуудын талаар мэргэжилтнүүд мэдээдэл хийж, санал солилцож зөвлөмж чиглэл өгч хамтран ажиллалаа. Уг сургалтанд хийт 98 алба хаагчид оролцсон.

Япон улсын Азийн хөгжлийн эрүүл мэндийг дэмжих сангийн тэргүүн Докио, Анагаах ухааны их сургуулийн хүндэт доктор Ютакай Имаи, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нүүр ам судлалын сургуулийн Хүүхдийн тэнхмийн багш Н.Дэлгэрцэцэг нар "Хүүхдийн амны хөндийн эрүүл мэнд", "Хүүхдийн шүдний эрүүл ахуй" сэдвүүдээр сургууль цэцэрлэгийн эмч нарт сургалт зохион байгууллаа. Мөн энэ үеэр Японы эрүү нүүрний төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын баг үзлэг оношлогоог аймгийн нэгдсэн эмнэлэг дээр зохион байгуулж, үзлэгт 247 хүн үзлэгт хамрагдаж 14 мэс ажилбарыг үнэ төлбөргүй үзүүлж, хамтран ажилласан байна.

Мөн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын баг Цагааннуур суманд очиж эрүүл мэндийн үзлэг оношлогоог зохион байгуулж нийт 112 насанд хүрэгчид, 21 хүүхэд, 4 жирэмсэн эхэд үзлэг, шинжилгээ хийсэн бөгөөд лавлагаа шатлалд 3 иргэнийг илгээсэн байна.

"Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд тэмбүү өвчний тархалтыг бууруулан улмаар устгах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор "Тэмбүүг устгая" 14 хоногийн аяныг аймгийн Авто тээврийн төв, Цагдаагийн газар, Орон нутгийн тээврийн жолооч нартай хамтран эхлүүлээ.

Хөвсгөл далайд байрлах "Эрчим-2" ахмадын амралт сувиллыг улсын болон орон нутгийн 800,0 сая төгрөгийн санхүүжилтээр 2019 онд ашиглалтад орон үйл ажиллагаа явуулж байгаа ба тус амралт сувилалд 8 дугаар сард нийт 235 ахмад настан амарч сувилуулсан байна.

Монголын багш, эцэг эхийн холбоотой хамтран сонсголын бэрхшээлтэй иргэдийн сонгогчийн боловсролыг нэмэгдүүлэх зорилготой сургалтыг зохион байгуулж, сургалтад Мөрөн сумын хэл, сонсголын бэрхшээлтэй 53 иргэн оролцсон. Тус сургалтанд сууснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуульд оролцох, бусдын нөлөөгүйгээр саналаа өгөх арга зүйд суралцаж, мэдээллийг цаг тухай бүрт хэрхэн авч байх талаар мэдлэг чадварыг эзэмшсэн, үр дүнтэй сургалт болсон.

Орон нутгийн төсвөөс нийгмийн халамжийн үйлчилгээг дараах байдлаар үзүүлсэн байна.Үүнд:

- Цаатны тэтгэмжийг 361 иргэнд олгож 56,1 сая төгрөгийг,
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 8 хүнд олгож 9,6 сая төгрөгийг тус тус олгожээ.

Улсын төсвөөс нийгмийн халамжийн үйлчилгээг дараах байдлаар үзүүлсэн байна.Үүнд:

- Халамжийн тэтгэврийг 2799 хүнд олгож 473,3 сая төгрөгийг,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт тусламжийг 196 хүнд олгож 17.7 сая төгрөгийг,
- Цалинтай ээжийн тэтгэмжийг 6919 иргэнд олгож 337,7 сая төгрөгийг
- Алдарт эхийн одонгийн мөнгийг 42 иргэнд олгож 4,2 сая төгрөг
- Ахмад настан хөнгөлөлт, тусламжийг 924 ахмадад олгож 107 сая төгрөгийг тус тус олгосон байна.

БНСУ-д ажиллах хүч илгээх санамж бичгийн хүрээнд 80 хүнийг бүртгэх квотыг ХХҮЕГ-аас ирүүлсэн бөгөөд 8-р сард бүртгэлийг зохион байгуулж, 44 иргэн бүртгүүлсэн байна.

Аймгийн хэмжээнд эхний 8 сарын байдлаар 258 иргэнийг ажилд зуучилсан бол 676 ажил хайгчаар бүртгүүлсэн байна.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122-р тогтоолоор батлагдсан Үндэсний боловсруулах үйлдвэрт хонь, тэмээний ноос бэлтгэн тушаасан малчин, мал бүхий этгээдийн урамшуулал олгох журмын дагуу баримт материалыг 23 сум 1 тосгоноос авч нэгтгэж байна.

ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 05 сарын 07 –ны өдрийн А/133 Тушаалын дагуу аймгийн Засаг даргын А/263 дугаар захирамжаар “Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих” ажлын хэсэг томилон Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул, Баянзүрх сумдад “Малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэх, тодорхойлох ажлыг зохион байгуулах удирдамжийн дагуу зөвлөмж өгч, хяналт тавьж ажилласан.

“Цаатны наадам - 2000 цааны баяр”-ын арга хэмжээний нээлтэд ХХААХҮ-ийн дэд сайд Ж.Сауле оролцож, орон нутагт ажиллан үүрэг чиглэл өглөө. 2018 оны жилийн эцэст 85 өрх 2396 толгой цаа тоологдон ба “Цаатны наадам - 2000 цааны баяр”-ын арга хэмжээнд баруун, зүүн тайгаас ирсэн 1200 гаруй цаанд ашиг шимийн судалгаа, биеийн үндсэн хэмжилт, эрүүл мэндийн үзлэг хийсэн.

08-р сарын 28-ны байдлаар Аймгийн нөөцөд 3,6 тн өвс, 88,3 тн тэжээл бэлтгэсэн, малчид иргэдийн хүчээр 44290 тн өвс, 145тн давс хужир, 11,6 тн гар тэжээл бэлтгэж 19,3 хувийн биелэлттэй байна. Энэ онд 16727 га талбайд үр тариа үүнээс 16558 га талбайд улаанбуудай, арвай 120, овъёос 24, хөх тариа 16, гурвалжин будаа 9, төмс 235,5, хүнсний ногоо 178,7, ногоон тэжээл 811, рапс 3453 га талбайд ту тус тариалалт хийснээс Ургацын урьдчилсан балансаар улаанбуудай 16558 га талбайгаас 23328 тн буюу нэг га талбайгаас 14 цн ургац төмс 235,5 га-с 2001 тн, хүнсний ногоо 178,7 га-с 1465 тн, ногоон тэжээл 811 га-с 1216 тн ургац хураан авахаар тооцлоо.

Энэ жилийн тариалсан талбайн ургалт хэвийн байгаа бөгөөд одоогийн байдлаар үр тариа аарцан болцын төгсгөл шатандаа байна. Энэ онд 13,0 га талбайд уриншийн боловсруулалт хийгдлээ. Төмс хүнсний ногооны түүвэр хураалт хийгдэж, техник шинэчлэлийн хүрээнд зарим аж ахуйн нэгжүүд трактор, чиргүүл дүүжин машин аваад байна. 2 аж ахуйн нэгжийн үрийн талбайд хянан баталгаа хийлээ. ЖДҮ хөгжүүлэх сангаас олгох хөнгөлттэй зээлийн мэдээллийг банкуудад хүргэлээ. Нийт 21 төсөл арилжааны 3 банкинд хүргэлээ.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

“Цаатны наадам-2000 цааны баяр” 2019 оны 8 дугаар сарын 16,17-ны өдрүүдэд Цагааннуур суманд зохион байгуулж, баруун зүүн тайгын 300 гаруй цаатан иргэд 1300 орчим цаа, урцтайгаа нүүдэллэн ирж Цагааннуурынхаа дэнжид отоглон гадаад дотоодын жуулчдад тайгын амьдралыг үзэх боломж нөхцлөөр хангасан арга хэмжээ боллоо. Цааны наадмын үеэр Зарь, Этэр, Янзаганы уралдаан, цаа дэлсэх тэмцээн, тэвэг, самар шидэх, Монгол үндэсний болон Тува бөхийн барилдаан, Цаатан гэр бүл шалгаруулах, цаачин хүүхдүүдийн дунд танин мэдэхүйн өртөөчилсөн тэмцээн, цаан поло, “Нүүдэл” буухиа, Галын наадам, тува бөөгийн

үзүүлбэр, аймгийн ХДТ, Цагааннуур сумын уран бүтээлчдийн тоглолт зэрэг олон арга хэмжээнүүд хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдлаа.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 44-р тогтоол, аймгийн Засаг даргын А/197-р захирамжийн дагуу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Дэлгэрхаан уулын тахилга, Цагаан адууны баяр, Дархад хурд-6 өв соёлын наадмыг мөн зохион байгууллаа.

Хөвсгөл аймгийн Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж “Нөхөрлөл хөгжил, арга хэмжээ” сэдэвт туршлага солилцох уулзалт арга хэмжээг 23 сум дундын ойн ангийн нөхөрлөлүүдийн дунд 2019 оны 8 дугаар сарын 1-ний өдөр 160 хүний төлөөллийг хамруулан туршлага солилцох уулзалт арга хэмжээг зохион байгуулж, салбар бүрээр нийт 17 заалт бүхий уриалга гаргалаа.

Найм. Цаг үеийн бусад мэдээлэл